



ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН ЧАДАВХЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



СУДАЛГААНЫ ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нээлттэй Нийгэм Форум нь иргэдэд тулгамдаж буй хууль зүйн үр дагавар бүхий бэрхшээл, түүнийг шийдвэрлэж буй арга хэрэгсэл, хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ авах өнөөгийн хэрэгцээ, боломжийг тодорхойлох судалгааг үндэсний хэмжээнд хийв. Уг судалгааг 2016 оны 5 - 11 дүгээр сард 7 аймгийн 30 сум, нийслэлийн 4 дүүргийн нийт 1630 иргэнийг хамруулан шууд ярилцлагын аргаар Хараат бус судалгааны хүрээлэнтэй хамтран хийж гүйцэтгэлээ.

Нийт судалгаанд оролцогсдын:


- 12,5 хувь нь орон нутагт аймгийн төвөөсөө дунджаар 200-аас дээш километрийн алсад, нийслэлд дүүргийн төвөөсөө дунджаар 10-аас илүү километр оршин суугаа сум, хороодын иргэд;
- 30,4 хувь нь эмзэг бүлгийн иргэд буюу өрхийн сарын орлого нь 300 000 төгрөгөөс бага, аймаг дүүрэг, олон улсын байгууллагаас ямар нэг хэмжээгээр тусламж авсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд байлаа.



СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

Монгол Улсын иргэдэд өдөр тутамд тулгарч буй бэрхшээл, түүнийгээ шийдвэрлэж байгаа зан төлвийг сүүлийн 3 жилд тулгарсан бодит байдалд үндэслэн судлахад иргэдийн 54,8 хувьд нь хууль зүйн үр дагавар бүхий ямар нэг бэрхшээл тохиолдсон гэж хариулжээ.

Хамгийн нийтлэг тохиолдож буй бэрхшээл нь ажил хөдөлмөр эрхлэлт, мөнгө санхүү, газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй холбоотой байгаа бөгөөд эдгээр нь нийт бэрхшээлийн 35,7 хувийг эзэлж байна.




- Ажил хөдөлмөр эрхлэлт
- Мөнгө, санхүү
- Газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Хөршийн эрх
- Нийгмийн даатгал, нийгмийн халамж
- Хэрэглэгчийн эрх
- Төрийн үйлчилгээ авах харилцаа
- Орон сууц, барилга, нийтийн аж ахуй
- Хууль сахиулах, цагдаагийн үйлчилгээ
- Суурь боловсролын үйлчилгээ
- Ялгаварлал
- Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох, нөхөн төлбөр
- Татвар, бүртгэл, шүүх, нотариатын үйлчилгээ
- Гэр бүлийн харилцаа

Ярилцлагад оролцсон иргэдийн тал хувь нь ямар нэг бэрхшээл тулгарсан үед шийдвэрлэх арга зам хайхгүй байх нь түгээмэл байгааг судалгааны дүн харуулав.

Энэ нь иргэд тулгарсан бэрхшээлийг хэрхэн шийдвэрлэх, ямар алхам хийхээ мэдэхгүй, эсвэл ямар нэг алхам хийхэд үл тусална гэж боддогтой холбоотой аж. Бэрхшээл тохиолдсон гэж хариулсан 894 иргэний 50.5 хувь нь түүнийг шийдвэрлэх ямар нэг оролдлого хийх буюу мэдээлэл тусалцаа хайх, байгууллага албан тушаалтанд хандаагүй байна. Ямар шалтгааны улмаас алхам хийгээгүйг дараах графикаас харна уу.




Бэрхшээл тулгарахад тодорхой алхам хийсэн иргэдийн хувьд бусдын дэмжлэггүйгээр асуудлаа шийдвэрлэх хандлага илүү байгаа нь (i) хэнд хандахаа мэдэхгүй, (ii) өөрөө шийдвэрлэж чадна гэж үзсэнтэй холбоотой байна. Харин шаардлагатай үед найз нөхөд, гэр бүл, танил талын хүндээ л ханддаг ажээ. Тодорхой алхам хийсэн гэж хариулсан 443 иргэний 60,7 хувь нь бэрхшээлээ шийдвэрлэхийн тулд бусдаас ямар нэг тусалцаа аваагүй байна.




Иргэд хэн нэгэнд хандаж тусалцаа аваагүйн шалтгаанаа дараах байдлаар илэрхийлж байна. Үүнд:



Тусалцаа авсан иргэдийн хувьд юун түрүүнд найз нөхөд, гэр бүл, танил талдаа хандахаас хуульч, өмгөөлөгчдөд хандсан нь харьцангуй цөөн байв.



Иргэд өөрт тулгарсан бэрхшээлтэй холбоотойгоор төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж мэдээлэл авах байдал хангалтгүй, хандсан ч мэдээлэл авч чадаагүй нь давамгай байна.



Мэдээлэл авахаар хандсан **21,9 %**

Мэдээлэл авахаар хандсан, авч чадаагүй **16,3 %**

Мэдээлэл авахаар хандаагүй **61,8 %**


Иргэдэд тулгарч байгаа бэрхшээлийг тодруулахад тал хувь нь төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагаас үүдсэн байв. Хувийн аж ахуйн нэгж, ажил олгогчид 23.4 хувьд нь бэрхшээл үүсгэгч тал болжээ.

Тулгарсан бэрхшээлээ шийдэхээр туслалцаа авсан иргэдийн 68,3 хувь нь орон нутгийн иргэд байгаа хэдий ч энэ нь төвийн бүсэд илүү хамаарч байна. Зүүн болон баруун бүсэд туслалцаа авсан иргэдийн тоо харьцангуй бага байлаа.

Судалгаанд хамрагдсан нийт 1630 иргэнээс өөрт нь тодорхой бэрхшээл тохиолдсоноос үл хамааран “Хэрэв ямар нэг бэрхшээл тохиолдвол хаашаа хандахаа мэдэх үү?” гэж асуухад 57,1 хувь нь “Мэдэхгүй” гэж хариулсан ба “Мэднэ” гэж хариулсан 700 иргэний 39,4 хувь нь холбогдох төрийн байгууллага, 24,3 хувь нь зохих шатны хуулийн байгууллагад, 19,1 хувь нь дүүрэг, хороо болон сум, багийн засаг даргад хандана гэж хариулсан байна. Эндээс иргэд дийлэнх тохиолдолд буюу 82,8 хувьд нь төрийн ямар нэг байгууллагад хандаж мэдээлэл, тусламж авах хандлагатай байгааг харж болно.


Иргэд бэрхшээл тулгарахад хуульч өмгөөлөгч гэхээсээ илүү сум, хороо, аймаг, дүүргийн засаг дарга, ажилтнаас туслалцаа хүсэж, вэб сайтаас мэдээлэл хайдаг байна. Бэрхшээл тохиолдох үедээ иргэдийн мэдээлэл туслалцаа авах хамгийн ойр, тохиромжтой гэж үзсэн эрх сурвалжуудыг эрэмбэлж харуулбал:

Тохиромжтой байгууллага, эх сурвалж (давхардсан тоогоор)




Иргэдийн талаас илүү хувьд нь Монгол Улсын хууль зүйн тогтолцоонд итгэх байдал дунд болон дундаас доош түвшинд байна. Тэр дундаа сүүлийн 3 жилд ямар нэг бэрхшээлтэй тулгарсан иргэдийн хууль, шүүхийн тогтолцоонд итгэх итгэл ямар ч бэрхшээлтэй тулгараагүй иргэдтэй харьцуулахад бага байна.

Хууль, шүүхийн тогтолцоо баян, ядуу ялгаварлахгүй үйлчилдэг (хувиар)



Мөн шүүхийн маргаанд оролцвол шударга хандана гэсэн итгэл бэрхшээл тулгарсан иргэдийн хувьд бага байна.

Шүүхийн маргаанд оролцвол надад шударга хандана (хувиар)



Монгол Улсын иргэд өөрт тохиолдсон аливаа бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг идэвх санаачлагатайгаар хайхгүй, тэр ч бүү хэл шаардлагатай мэдээлэл, туслалцаа хаанаас хэрхэн эрж хайхаа мэдэхгүйгээс тулгамдаж буй асуудлаа тэр бүр шийдэж чадахгүй байна. Мөн хууль, шүүхийн тогтолцоонд итгэх итгэл сул, төрийн үйлчилгээ, хүнд суртал, чирэгдэлтэй гэж үзэж байгаа зэргээс шалтгаалан иргэд хуулиар олгогдсон олон боломжийг ашиглаж, ашиг сонирхлоо хамгаалах, эрхээ хэрэгжүүлж чадахгүй буюу эрх зүйн чадавх нь сул байгааг судалгааны дүн харууллаа.